

**БАРУУН ӨМНӨД АЗИ ДАХЬ ЦЭРЭГ-
УЛС ТӨРИЙН БАЙДЛААС****Д. Баярхүү**

Сүүлийн жилүүдэд өрнөдийн цэргийн хэвлэлүүдэд НАТО-гийн үүрэг зорилгын шинэ чиглэлийг тодорхойлсон мэдээ материал нийтлэгдэх нь олширлоо. Цэргийн түрэмгий энэ эвслийн гишүүд НАТО-гийн хилийн чандад явуулах урт хугацааны программыг заасан баримт бичгийн төслийг АНУ-ын санаачлага, шахалтаар хэлэлцэж эхэлжээ. Умард атлантын эвсэл Европын байлдааны ажиллагааны талбараас гадна байлдаан хийхэд бэлэн байх ёстой гэсэн сэдэв хэлэлцэж байгаа нь тэрхүү төслийн гол санаа болж байна. НАТО-гийн стратегид «умард», «өмнөдийн» харилцаа онцгой байр эзлэх болж, тэгэхдээ өрнөдийн гүрнүүд шинэ тулгар хөгжиж буй улсуудын нөөц баялагт нэвтрэх гэсэн шунахай үзэл санааг урьдал болгож байна. Үүний сацуу «амин чухал эрх ашгийн бүс» гэгчээ өргөжүүлж, ингэхдээ олон зуун мянган километр алслагдсан нутаг районд байлдааны ажиллагаа явуулах замаар уг бүс нутгийг тэлэх санаархалтай байна. НАТО-гийн түрэмгий бүлгийнхэн, юуны өмнө АНУ-ын дайнд эрх баригчид ямар ч болов аргаар жанжлах түрэмгий бодлогоо хэрэгжүүлэхийн тулд дотоод хэрэгт нь хөндлөнгөөс оролцож, айлган сүрдүүлэхээс эхлээд цэргийн хүчээр шууд түрэмгийлэх хүртэл арга хэрэглэж байгааг сүүлийн үед Персийн булан, Энэтхэгийн далайн сав газар болж байгаа хэрэг явдал тод харууллаа. Афганистан, Иранд гарсан хувьсгал, Энэтхэгийн төвийг сахисан гадаад бодлого, Ардчилсан Йемен, Этиоп оронд хийгдэж байгаа нийгэм-эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлт, Ойрхи Дорнодод Израилийн булаан эзлэгчдийн хавсарган нэгтгэх бодлого, Ливанд АНУ шившигтэйгээр ялагдаж, түүний бодлого арабын өргөн олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарсан зэрэг нь дэлхийн бөмбөрцгийн энэ бүс нутагт империализмын төлөвлөгөө ахицгүй болж байгааг илт харуулж байна. Энэ бүхэн нь далайн чанад дахь стратегчдыг ихээхэн бухимдуулж байгаа юм. Тав дахь жилдээ сунжирч байгаа Иран-Иракийн дайн Персийн буланд милитарист бэлтгэлээ шамдуулж, тус бүс нутгийн байдлыг улам хурцатгахад чиглэсэн АНУ-ын бодлого идэвхжих үндэс суурь болсон юм. АНУ Пакистаныг илэрхий цэрэгжүүлж, энэ бүс нутагт империалист цохилтын бааз, түшиц газар болгон хувирах эхлэлийг тавив.

Өнөө үед дэлхийн янз бүрийн орны олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд Энэтхэгийн далайн сав газрыг оролцуулан, Баруун өмнөд Ази, Персийн булангийн район, Дундад Дорнодод бий болсон цэрэг улс төрийн байдалд анхаарлаа хандуулж байна. Чухамдаа дэлхийн

бөмбөрцгийн энэ бүс нутаг дэлхийн шинэ дайн дэгдэх «аюултай цэг» болж байгаад үүний гол учир байгаа юм. «Империалистуудын хувьд Ази тив бол социалист улсуудын эсрэг тэмцлийн бас нэг дорнод фронт болж байна. АНУ тэнд цэргийн бааз, түшиц газар олныг байгуулж, цөмийн зэвсэг байрлуулж байна. Энэ зэвсгийн тусгалын хүрээнд зөвхөн Зөвлөлт Холбоот Улсын нутаг дэвсгэр төдийгүй, Ази, Номхон далайн сав газрын бүх улсуудын нутаг дэвсгэр орж байгаа юм. Чухамдаа Ази тив АНУ-аас дайн байлдаанд цөмийн зэвсэг хэрэглэсэн анхны талбар болсныг дурдахгүй байж болохгүй»¹ гэж зөвлөлтийн нам, төрийн удирдагч Константин Черненко тэмдэглэсэн билээ.

Пакистан бол тус бүс нутаг дахь империализмын гол түшиц газар мөн

1979 оны хоёрдугаар сард Иранд АНУ-ын талыг баримталсан шагийн дэглэм ард түмний зэвсэгт тэмцлийн дунд сүйрэн унасны дараа тус бүс нутагт үндэсний эрх чөлөөний тэмцлийг нухчин дарах зориулалттай цэргийн түрэмгий СЕНТО эвсэл бутран задарч империализмын гар хөл болсон Пакистанд генерал Зия-Уль-Хакийн цэргийн дэглэм тогтсон билээ. Израиль Ойрхи Дорнодод, Пакистан Баруун Өмнөд Азид харгис цагдаа, империализмын «гол цайзын» үүрэг гүйцэтгэж байна. Пакистаны нутаг дэвсгэр бүхэлдээ хөрш зэргэлдээ Афганистан, Энэтхэгийн дотоод хэрэгт оролцох өрнөдийн тусгай албаныхны томоохон түшиц газар болжээ. Вашингтоныхон Пакистаны цэргийн эрх баригчдын милитарист санаархалыг элдвээр өөгшүүлэн дэмжиж, «Америкийн стратегийн ашиг сонирхлыг хангахад одоо Пакистан л гол үүрэг гүйцэтгэх ёстой» гэж үзэж байна. Сүүлийн үед Вашингтоны тусгай даалгаварт төлөөлөгчид Пакистанд байнга очиж, үйл ажиллагаагаа зохицуулах талаар «шалган зааварлах аялал» хийх нь улам олширлоо. Зөвхөн сүүлийн нэг жилийн дотор ийм зорилгоор Исламабадад айлчлагсдын дотор АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Жорж Шульц, Батлан хамгаалах Яамны сайд Каспар Уайнбергер, БНААфГУ-ын эсрэг зарлаагүй дайныг санаачлагчдын нэг Збигнев Бжезинский, АНУ-ын дэд ерөнхийлөгч Жорж Буш, Сенатын зэвсэгт хүчний асуудал эрхэлсэн комиссын дарга Жон Тауэр, Тэнгисийн цэргийн хүчний Яамны сайд Жон Леман болон бусад төлөөлөгчид оржээ. Тэд Пакистанд ямар асуудал хэлэлцэж, юуны тухай тохирсон нь мэдээж юм. Тэд хоёр талын цэрэг-улс төрийн хэлхээ холбооны хүрээнд АНУ-аас нийтдээ 3,2 миллиард долларын үнэ бүхий тусламж үзүүлж, Пакистаны армийг шинэчлэн зэвсэглэх өргөн хүрээтэй программыг хэрэгжүүлэх, нөгөө нь Афганистаны эргэн тойронд түгшүүртэй байдлыг дэвэргэх гэсэн хоёр л асуудал дээр тогтож ярилцжээ. Тэд ингэж айлчлахдаа ёс мэт Афганы хувьсгалын эсэргүү дээрэмчдийн хуарангаар очдог байна. Пакистан улс батлан хамгаалах талаар өөрийнх нь хэрэгцээнээс үлэмж давсан зэвсэг техник, түүний дотор давшилтын зэвсгийг АНУ-аас авч, энэ оронд гадны ямар аюул занал учраагүй байхад ингэж зэвсэглэж байгааг Вашингтоныхон өөрсдөө ч сайн мэдсээр атлаа энэ тусламжаа бас дахин нэмэгдүүлэх тухай ярилцаж байна. Гурван жилийн өмнө Вашингтон, Исламабадын хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу Пакистан улс цэрэг-

¹ В дружественной обстановке. Речь товарища К. У. Черненко., «Правда» 24.V.1984

эдийн засгийн «иж бүрэн тусламж», АНУ-аас авах болсон бөгөөд 1982 онд Вашингтонд Зия-Уль-Хакийн хийсэн анхны айлчлалын үед энэ тухай бүр нарийн тохиролцсон юм. Энэтхэгийн хэвлэлд АНУ хамгийн орчин үеийн сөнөөгч—бөмбөгдөгч Ф—16 нисэх онгоцыг Пакистанд нийлүүлж байгааг мэдээлээд, хөрш зэргэлдээ улсууд, тухайлбал Энэтхэг улсын томоохон хотуудад цөмийн цохилт өгч чадах эдгээр нисэх онгоц НАТО-гийн эвсэл дэх АНУ-ын холбоотнуудад хүртэл байдаггүйг тэмдэглэжээ.² Пакистаны зэвсэгт хүчин иймэрхүү 40 нисэх онгоц (нэг эскадриль), алсаас илрүүлэн сэрэмжлэх радиолокацын АВАКС системтэй төсөө бүхий тойрныг хардаг радиолокацын системээр тоногдсон «Хокай Е--2» гэдэг нисэх онгоц, мөн М--48, М--60 гэдэг хүнд танк, том калибрын өөрөө явагч холын тусгалт гаубиц их буу, хөлөг онгоцны «Гарпун» хэмээх пуужин, байлдааны нисдэг тэрэг (вертолет)-ийг АНУ-ын тусламжийн хүрээнд авч байна. Пентагоныхон цөмийн цэнэг бүхий далавчит пуужингаа байрлуулахаар Пакистаны Раскох, Гвадарын районд цэргийн томоохон барилга байгууламжийн ажлаа одоо ид явуулж байна.³ Ийнхүү Пакистан улс пентагоны түрүүлж цохилт өгөх цөмийн зэвсгийн түшиц газар болж байна. Үүний сацуу өрнөдийн гүрнүүд өөртөө цөмийн зэвсэг бүтээх гэсэн Исламабадын эрх баригчдын санаархлыг өөгшүүлж, пакистаны цөмийн мэргэжилтнүүдийг АНУ-д сургаж бэлтгэхийн зэрэгцээ цөмийн зэвсгийн гол түүхий эдийг Пакистанд нийлүүлж байна.

Пакистаны цэргийн дэглэмд японы эрх баригчид ч бас дэмжлэг үзүүлж байна. Үүнийг японы ерөнхий сайд Ясухиро Накасонэ болон бусад төлөөлөгчид Пакистанд айлчилсан явдал гэрчилж байна.

Пакистаны талаар хятадын удирдагчид хоёр нүүрт, зохисгүй байр суурь баримталж байна. АНУ-ын стратегийн түрэмгий санаархал Баруун өмнөд Азийн бүс нутагт хурцаар илрэхийн хамт Бээжин-Исламабадын цэрэг-улс төрийн хэлхээ холбоо эрс идэвхжиж, хоёр талын дээд тушаалын төлөөлөгчид харилцан айлчлах нь улам ихсэв. БНХАУ-ын дарга Ли Сяньнянь, Гадаад явдлын яамны сайд У Сюэцянь нар Пакистанд, Пакистаны Гадаад явдлын яамны сайд С. Якуб Хан Хятадад айлчилж, хоёр тал бусад салбарын, түүний дотор цэргийн төлөөлөгчид үе үе солилцож байна. Хятадын төлөөлөгчид ийнхүү айлчлахдаа өнөө л Пешавар дахь афганы дээрэмчдийн хуарангаар ордог зуршилтай болжээ. АНУ-ын тагнуулын төв газар болон бусад хорлон сүйтгэх төвүүдийн хөрөнгөөр тэжээгдэн тэтгэгдэж байгаа хөлсний алуурчдыг Бээжингээс ирсэн зочид «жинхэнэ эх орончид», «партизаныуд» гэж нэрлэж байна. Ер нь санаанаасаа зохиосон «афганистаны асуудал» гэгчийг бий болгосон тэр цагаас хятадын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Бээжингийн албан ёсны төлөөлөгчид тэдгээр алан хядагчдыг «эх орончид» болгон дүрсэлдэг болжээ.

Пакистаны цэргийн дэглэмийн оршин тогтноход хятадын цэрэг-эдийн засгийн тусламж ихээхэн үүрэг гүйцэтгэж байна. 1968 оноос Хятад улс Исламабадад «буцалтгүй тусламжийн» нэрээр байлдааны зэвсэг техник нийлүүлж, жил ирэх тутам түүнийхээ цар хүрээг байнга өргөжүүлж байна. 1979 он гэхэд Пакистаны арми БНХАУ-аас 350 сөнөөгч нисэх онгоц, сургалтын 45 нисэх онгоц, 750 танк, 120 мм, 82 мм-ийн 400 миномет, торпед

² «Хиндустан таймс» сонин. 1983.XII.4.

³ «Хакикате инкилабе саур» Кабулын сонин. 1984.VII.9.

13 хөлөг, асар их хэмжээний галт зэвсэг, сум хэрэгсэл авсан байв. БНХАУ-ын тусламжаар Таксил, Камре хотод буудлагын зэвсэг, сум галт хэрэгсэл, танкийн хөдөлгүүр үйлдвэрлэх завод, нисэх онгоцны засварын газар байгуулагдсан байна.⁴

Удахгүй Пакистанд Хятадаас 65 сөнөөгч нисэх онгоц, зенитийн пуужин, эскадрийн мина зөөгч хөлөг онгоц, эргүүлийн хөлөг онгоц, шумбагч завь эсэргүүцэх хөнгөн хөлөг онгоцыг «буцалтгүй тусламжийн» журмаар нийлүүлэх гэж байна. Хятад улс Исламабадынханд 2,5 миллиард долларын зэвсэг нийлүүлж, Каракорумын стратегийн ач холбогдолтой засмал зам тавьж өгсөн нь Энэтхэг, Афганистаны аюулгүй байдалд заналхийлж байна.

Пакистан—АНУ, Пакистан—Хятадын сүлбэлдээн ийнхүү улам гаарч, тэд цэрэг-улс төрийн болон гадаад бодлогынхоо үйл ажиллагааг уялдуулан зохицуулах алхам хийж байгаа нь Баруун Өмнөд Ази төдийгүй нийт өргөн уудам Ази тивийн энх тайван, аюулгүй байдалд ноцтой заналхийлж, олон улсын байдлыг улам түгшүүртэй болгож байна.

Төвийг сахьсан Энэтхэгт заналхийлж байгаа нь

Америкийн тэнгисийн цэргийн хүчний байлдааны хөлөг онгоцууд Энэтхэгийн эргийн дагуух стратегийн чухал районы орчим эргэлдэх нь улам олон боллоо. Сүүлийн үед Бомбей хотоос холгүй орших Энэтхэгийн нефтийн томоохон орд газар—Бомбей—Хай районд америкийн «Люис Пуллер» гэдэг байлдааны томоохон хөлөг онгоцыг оролцуулсан тактикийн сургууль болжээ. Үүнтэй холбогдуулан Энэтхэгийн долоо хоног тутмын «Блицц» сэтгүүлд энэ орд газрыг АНУ дээд зэргээр сонирхож байгааг заан тэмдэглэсэн байна.⁵ Бомбей-Хайн орд газар Энэтхэгийн нефтийн тэн хагасыг нь гаргадаг бөгөөд АНУ эртнээс нарийн нягт боловсруулж төлөвлөсөн ажил явууллагаа үйлдэж буй объект юм.⁶ АНУ-ын тагнуулын төв газар нь энэ объектын тухай янз бүрийн тоо баримт цуглуулах, түүнд америкийн тагнуул туршуулуудыг нэвтрүүлэх зорилгоор тусгай салбар байгуулжээ. Вашингтоны тусгай албаныхан Энэтхэгийн нефтийн орд газруудад хорлон сүйтгэх ажиллагаа үйлдэхийн тулд Оман, Пакистаны нутагт тусгай төв байгуулж, алан хядагчдыг бэлтгэж байна.

Сүүлийн үед Энэтхэгийг илэрхий өдөөн хатгасан империалист хүчний түрэмгий байр суурь ийнхүү идэвхжихийн хамт АНУ, Канад, Англи, Өрнөд Германд байгаа салан тусгаарлагч этгээдүүдийн үйл ажиллагаа илт идэвхжиж, Энэтхэгийн баруун хойд район—Пенжаб, Жамму, Кашмир муж улсын байдал түгшүүртэй хэвээр байна.

Пенжабын байдал: Энэтхэгийн засгийн газар Пенжабт болж байгаа сүүлийн гурван жилийн хэрэг явдлын тухай «Цагаан ном» нийтлүүлсэн юм.⁸ Салан тусгаарлагчид энэ муж улсыг Энэтхэгээс салгаж, гадаадынхны тусламжтайгаар тусгаар тогтносон «Сикхийн улс» байгуулах зорилго тавьж байгааг уг номд хөтөлбөргүй баримтаар нотолсон байна. Энэ хавийн нутгийг эзэгнэсэн «Халистан улс» гэгчийг бий болгох санааг анх хэн сэдэж, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд хэн

⁴ «Красная звезда». 5.1.1982.

⁵ «Блицц», 29.V.1984.

⁶ «Дейли» Бомбейн сонин. 29.V.1984.

⁷ «Правда» 15.VII.1984.

эд материалын болон цэргийн тусламж үзүүлсэн нь одоо нууц биш болжээ. Ийм улс байгуулахын төлөө хөдөлгөөнийг АНУ дэмжиж байна гэж «Халистан улсын» «ерөнхийлөгч» гэж өөрийгөө дур мэдэн нэрлэсэн Жагжит Сингх Чаухан гэгч 1983 оны тавдугаар сард нууж хаалгүй мэдэгдсэн юм. «Энэтхэгийн эсрэг чиглэсэн салан тусгаарлах хөдөлгөөний нэг удирдагч өрнөдийнхний онцгой ивээлд дулдуйдаж байна» гэж Индира Ганди тэмдэглээд, Чаухан гэгч тэр этгээд америкийн конгрессын нөлөө бүхий хэд хэдэн гишүүнтэй нягт холбоотой байгаа тухай хэвлэлийн мэдээг иш татсан юм.⁹ Пакистан улс Энэтхэгийн засгийн газрын эсрэг чиглэсэн энэ хөдөлгөөнийг дэмжиж, «Халистаны чөлөөлөх арми» гэгчийг байгуулахад бэлэн байгаагаа зарлахын хамт, сикхийн хэт даврагч этгээдүүдийг элсүүлэх ажлыг гардаж байна.

Тоглоомын «Халистан улс» байгуулах төлөвлөгөөний янз бүрийн хувилбарыг Өрнөдөд боловсруулж байна. Иймэрхүү хувилбарт Энэтхэгийн хууль ёсны засгийн газрын эсрэг «сунжирсан дайн» дэгдээж, энэ дайныг Пенжабын хэт даврагчид гардан явуулах ёстой гэдгийг зааж байна. Ийм төлөвлөгөөний дагуу алан хядагчдад санхүү, эд материалын тусламж үзүүлэх зорилготой «үйл ажиллагааны хороод» гэгчийг АНУ, Канад, Англид байгуулжээ. Энэ зорилгодоо өрнөдийн тагнуулын албадын идэвхтэй дэмжлэгээр 10 сая фунт стерлингийн хэмжээтэй тусгай фонд бий болгожээ. Энэ их мөнгийг хорлон сүйтгэх, улс төрийн аллага үйлдэхэд зориулах ажээ. Хэт даврагчдын «үхлийн эскадроны» алж хороох зүтгэлтнүүдийн нэрсийн жагсаалтад Энэтхэгийн удирдагчид, Энэтхэгийн армийн генералууд, олон нийтийн нэрт зүтгэлтнүүд оржээ. Империалист улсууд, мөн Пакистаны түлхээсээр дээрх хэт даврагсдын төлөөлөгчид болох хөлсний 3 этгээд 1984 оны 10-р сарын 31-нд Энэтхэгийн ерөнхий сайд Индира Гандийн амь насанд халдаж, түүний амийг зэрлэгээр хороожээ. Энэ бол Энэтхэгийн дотоод, гадаад бодлогын нааштай чиг шугамыг өөрчилж, тус орныг дотроос нь задлан бутаргаж, түүний газар нутгийг нь таслан авах гэсэн харгис хүчний балмад оролдлого мөн болохыг Энэтхэгийн шинээр томилогдсон ерөнхий сайд Ражив Ганди болон бусад удирдагчид, Энэтхэгийн хэвлэл болон дэлхийн олон орны хэвлэл, мэдээллийн хэрэгсэл цохон тэмдэглэж байна.

Жамму, Кашмирийн байдал. Пакистаны цэргийн дэглэм Энэтхэгийн Жамму, Кашмир муж улсын эзлэгдсэн хэсгийг тус улсын эсрэг түрэмгийлэл үйлдэх түшиц газар болгож байна. Удахгүй тэндхийн Музаф-фарабад, Равалкот хотоос холгүй нисэх онгоцны хоёр буудал барьж дуусгах бөгөөд исламабадынхан энэ ажилд 340 сая рупий төсөвлөжээ. Эдгээр объектыг ашиглалтад оруулснаар Пакистаны агаарын цэргийн хүчний нисэх онгоцууд Энэтхэгийн хил орчмын чухал газрын чиглэлд нислэг хийх боломжтой гэнэ. Пакистан улс Жамму, Кашмир муж улсын эзлэгдсэн хэсэгт цэрэг дайны бэлтгэлээ эрс идэвхжүүлж байгааг одоо тэнд байгаа пакистаны 350 мянган хүнтэй цэргийн бүлэглэл дээр цэргийн шинэ шинэ анги нэмэн байрлуулж байгаа хэрэг явдал харуулж байна.¹⁰ Энэ районд Пакистаны армийн танкийн цэргийн 30 гаруй хувь нь бөөгнөрч, инженерийн барилга байгууламж хийж, зам холбооны шугам тавьж байна. Пакистаны тал ийнхүү цэрэг-дайны адал балмад алхамд илэрхий бэлтгэхийн зэрэгцээ энэ районд түгшүүртэй байдлыг байнга өдөөн дэвэргэж, Энэтхэгийн хил рүү үе үе

⁹ «Фигаро» Францын сонин. 12.VII.1984.

¹⁰ «Декан Геральд» 26.VII.1984.

буудаж, пакистаны сөнөөгч нисэх онгоцууд Нубра гэдэг уулын хөндийн районоор Энэтхэгийн агаарын хилийг зөрчиж байна. Ийм нөхцөлд Ладакх районы Нубрагийн хөндийд байрласан Энэтхэгийн цэргийг байлдааны бүрэн бэлэн байдалд оруулахад Энэтхэгийн тал арга буюу хүрчээ.

Афганистаны эсрэг явагдаж байгаа зарлаагүй дайн

БНААфГУ-ын эсрэг чиглэсэн зарлаагүй дайн зургаа дахь жилдээ үргэлжилж байна. Энэ дайнд афганы феодал, бурангуй этгээдээс эхлээд АНУ-ын Тагнуулын төв газар, Пентагоны мэргэжлийн тагнуулчдыг хүртэл харгис бүх хүч нэгдэн нийлж байна. Энэ балмад дайныг зоригжуулан зохион байгуулагч нь Вашингтоны засаг захиргаа, гардан хэрэгжүүлэгч нь Исламабадын харгис эрх баригчид гэдэгт эргэлзэх зүйл алга. АНУ болон түүний холбоотнуудын хөрөнгө мөнгөөр хувьсгалын эсэргүүчүүдийн хуаранг байгуулж зэвсэглэн, алан хядах ажиллагаанд тэднийг сургаад Афганистанд шургалуулж байна. Ийм хуаран зөвхөн Пакистанд 100 гаруй байгаа бөгөөд тэнд ажиллаж байгаа америк сургагч 300-аас давж байна.¹¹ Мөн иймэрхүү хуаран Пакистанаас гадна Иран, Хятадын нутагт байгаа юм. Эдгээр хуаранд АНУ-аас гадна Англи, Франц, Хятад, Саудын Араб, Египетийн сургагч нар ажиллаж байна. Афганы хувьсгалын эсэргүү дээрэмчдийн гурван хуаранг Пакистанаас БНХАУ-ын Шинжаан-Уйгурын өөртөө засах орны өмнөд хэсэгт аль хэдийнэ нүүлгэн аваачжээ.¹² Тагнуулын төв газрын 300 зааварлагч, тагнуул туршуулыг Исламабад хотод суугаа АНУ-ын Элчин сайдын яамны ажилтан Роберт Ласар удирдан чиглүүлж байгааг¹³ хэвлэлд заан тэмдэглэж байна. АНУ Афганы эсрэг дээрэмчдэд орчин үеийн зэвсэг техник нийлүүлэх явдлаа жил ирэх тутам өргөжүүлж байна. Пентагоны төсөвт энэ зорилгод 1983 онд 100 сая доллар зарцуулсан бол 1984 онд энэ зардал 125 сая долларт хүрэв.¹⁴ Англи бас ийм зорилгоор 18 сая фунт стерлинг, ХБНГУ 60 сая марк, Япон 4 миллиард иен төсөвлөжээ. АНУ-ын албаны хүмүүсийн хүлээн зөвшөөрснөөр, Цагаан ордныхон афганы хувьсгалын эсэргүүчүүдийн ялт ажиллагааг санхүүжүүлэхэд зөвхөн 3 жилд 300 сая гаруй доллар зарцуулжээ. Вашингтоныхон одоо эдгээр хөлсний дээрэмчдэд агаарын довтолгооноос эсэргүүцэн хамгаалах систем, хамгийн сүүлийн үеийн зенитийн пуужин, том калибрийн пулемет, гранатометыг улам олноор нийлүүлж байгаа бөгөөд АНУ-ын зэвсгийг эздэд нь хүргэх ажлыг Пакистаны тусгай албаныхан гардан гүйцэтгэж байна. Гурав дахь орны далбаа бүхий хөлөг онгоцонд эдгээр зэвсгийг ачиж, Пакистаны боомтуудад хүргэмэгц Пакистаны тал хамгаалалтдаа авч, тээвэрлэдэг ажээ.¹⁵

БНААфГУ-ын эсрэг үзэл суртлын хорлон сүйтгэх ажлыг толгойлогч нь мөн л Вашингтоны засаг захиргаанаас өөр хэн ч бишээ. Афганистаны чиглэлд явуулж байгаа дайсагнасан радио суртал нэвтрүүлэг янз бүрийн хэл дээр улам ихдэж байна. Тагнуулын төв газар энэ ажилд сая гаруй доллар зарцуулжээ. Өрнөдийн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, түүнтэй эвсэн сүлбэлдэх замд орсон бээжин-

¹¹ «Советская Россия» 7.VII . 1984.

¹² «Үнэн», 1984.VII.5

¹³ «Блиц» 9.VII.1984.

¹⁴ Мөн тэнд.

¹⁵ «Нэшнэл геральд» 7.VII.1984.

гийн суртал нэвтрүүлэг Афганистаны ардын ардчилсан хувьсгалын эргэлт буцалтгүй үйл явц, зөвлөлт-афганы найрамдалт харилцааг мушгин гуйвуулж, тус бүс нутагт энх тайван, тогтвортой байдал тогтоохын төлөө үр бүтээлтэй яриа хэлэлцээ хийх зарчимт байр суурь баримталж байгаа БНХАУ-ын хувьсгалт засгийн газрыг дайран давшилсаар байна. Тэд ингэхдээ санаанаасаа худал цуурхал тараан баримтыг гуйвуулах, гүжирдэн гүтгэх зэрэг элдэв арга хэрэглэж түрэмгий бодлогынхоо мөн чанарыг өнгөлөн далдлахыг оролдож байна. Гэвч ийм оролдлогод төөрөлдсөн хүмүүс ч сүүлдээ үнэн учрыг ойлгож мэддэг болжээ. Чухам хэн Афганы ард түмэнд туслаж, харин хэн дайсагнаж байгааг дэлхийн дэвшилт хүн төрөлхтөн сайн мэдэж байгаа билээ.

АНУ-ын засаг захиргаа БНААфГУ-ын эсрэг зарлаагүй дайныг зоригжуулан зохион байгуулснаараа чухамдаа олон улсын аллага хядлагыг өөгшүүлэн дэмжиж байна. Гэтэл АНУ-ын ерөнхийлөгч, төрийн нарийн бичгийн дарга нар олон улсын аллага хядлагатай тэмцэх явдал бол өрнөдийнхний гадаад бодлогын үндэс мөн гэж аман дээрээ зарлаж байгаа боловч хэрэг дээрээ тэд Афганистаны эсрэг аллага хядлагын кампанийн толгойлогчид мөн болохоо улирах цаг тутам харуулж байна. АНУ эртний соёлтой Афган орны соёл, түүхийн үнэт баялгийг цөлбөн дээрэмдэж, түүний энх цагийн бүтээн байгуулалтыг нь бусниулан, гэм зэмгүй сэхээтэн, хөдөлмөрчдийг алж устгах бузар хэрэгт голлон оролцож, тус орныг дундад зууны харанхуй байдалд эгүүлэн оруулах гэсэн хувьсгалын эсэргүү, шашны харгис бүлгийнхэнд ихээхэн тусламж дэмжлэг үзүүлж байна. Ингэж байгаагаараа Вашингтоныхон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг зөрчиж байна.

х х х

Одоо вашингтоныхон хорь гаруй улс орон байдаг Баруун өмнөд Ази, Ойрхи болон Дундад Дорнодын өргөн уудам нутгийг хамарсан стратегийн төв командлал гэгчийг байгуулах төлөвлөгөөгөө илт зарлаж байна. Энэ төлөвлөгөөгөөр бол үнэн хэрэгтээ дээрх бүс нутгийн улс оронд АНУ-ын засаг захиргааны хүлээн зөвшөөрч болшгүй гэж үздэг дотоодын ямар нэг хэрэг явдлыг далимдуулан тэдгээр орны алинд ч АНУ цэрэг зэвсгийн хүчээр хөндлөнгөөс оролцох, хүчирхийлэх эрхийг өөртөө олж авч байна гэсэн үг юм. «Энэ бол олон улсын дээрмийн номлол юм. Түүний утга учир энгийн юм. Юу гэвэл, тухайн нутгийн орнуудад гарч байгаа дотоодын аль нэгэн өөрчлөлт вашингтоныхоны санаанд нийцэхгүй бол тэд тэдгээр оронд өөртөө хэрэгтэй дэглэмийг зэвсгийн хүчээр тогтоохоос буцахгүй гэсэн үг юм. Тусгаар тогтнол, бүрэн эрхийнхээ төлөө үнэхээр санаа тавьдаг улс орон бүр энэ төлөвлөгөөг буруушаан няцаахгүй байж чадахгүй»¹⁶ гэж Андрей Громыко тэмдэглэсэн байна.

Баруун өмнөд Ази дахь байдал түгшүүртэй болж тэнд дайны гал дүрэлзэх аюул улам ихсэж байна. Ийм нөхцөлд тус бүс нутгийн төдийгүй нийт Азийн дэвшилт улс түмэн, түүний дотор энхийг эрхэмлэгч монголын ард түмэн энх тайвныг сахин хамгаалахын төлөө цуцалтгүй тэмцэж байна.

¹⁶ «Правда», 19.11.1983

ИЗ ВОЕННО-ПОЛИТИЧЕСКОЙ ОБСТАНОВКИ В ЮГО—ЗАПАДНОЙ АЗИИ

(Р е з ю м е)

В последние годы резко усиливаются происки империализма и его пособников в Юго-Западной Азии. В противоборстве с мировым социализмом, силами мира, национального освобождения и социального прогресса американский империализм и его союзники выбрали военный режим Пакистана в качестве основного опорного пункта в этом регионе. Они предоставляют Пакистану огромную сумму денег для приобретения им современного оружия и оснащения его армии. Автор статьи, приводя конкретные факты, излагает, как военный режим Исламабада с помощью США, Англи, Японии и Китая превращает свою страну в «горячую точку» напряженной военно-политической обстановки в Юго-Западной Азии.

Пакистанский военный режим все активнее выполняет волю внешних империалистических и гегемонистских сил вопреки коренным интересам своего народа. Он вместе с империализмом и гегемонизмом выступает ярким противником апрельской революции, которую афганский народ совершил под руководством Народно-Демократической партии Афганистана для развития своей страны по пути строительства нового общества. Исламабадский военный режим, агенты ЦРУ и сотрудники спецслужб ряда других стран, как пишет автор статьи, обучают в специальных лагерях на территории Пакистана большое количество наёмных бандитов-афганских контрреволюционеров и засылают их в Народно-Демократическую Республику Афганистан для саботажа и подрывной деятельности, разрушения и убийства. Эти их действия можно квалифицировать как непрерывающуюся настоящую необъявленную войну против НДРА, что объективно обостряет военно-политическую обстановку в Юго-Западной Азии.

Наряду с этим империализм и гегемонизм, их подручные активизируют свою антииндийскую кампанию с тем, чтобы сбить Индию с пути положительного курса во внутренней и внешней политике. Они ведут широкую подрывную деятельность против Индии, посягая на государственный суверенитет и территориальную целостность этой страны. При этом применяются самые низкопробные, авантюрные методы. В особенности экстремистские элементы-сепаратисты из религиозной общины сикхи, как подчеркивает автор статьи, со всей силой стремятся к тому, чтобы создать так называемое «государство Халистан» из индийского штата Пенджаб, провинций Джамму и Кашмир и других территорий.

В своих авантюрных действиях сепаратисты и их покровители прибегают к методам кровавого террора против руководящих государственных и общественных деятелей Индии, о чём ярко свидетельствует зверское убийство их платными агентами Премьер-Министра Индии Индиры Ганди 31 октября 1984 года.

Все это, как отмечает автор в заключении статьи, делает напряженной военно-политическую обстановку в Юго-Западной Азии и требует дальнейшей активизации борьбы всех миролюбивых сил Азии, включая этот регион.